



## БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 12 сарын 12 өдөр

Дугаар А/434

Улаанбаатар хот

### Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29.2 дахь хэсэг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25.2.1 дэх хэсэг, Засгийн газрын 2017 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 243 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд хөтөлбөрийг 1 дүгээр, хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө, удирдлага, зохицуулалтаар ханган ажиллахыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлд даалгасугай.

3. Дүүргийн дэд хөтөлбөр болон үйл ажиллагааны төлөвлөгөөний үр дүн, биелэлтийг жил бүр тайлагнаж, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний зөвлөлд хүргүүлж ажиллахыг Эдийн засаг, хөгжлийн асуудал хариуцсан төслийн удирдагч-Засаг даргын орлогч Д.Уламбаярт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Т.БАЯСАХ